



**ОРХОН АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГЫН ТУШААЛ**

2025 оны 11 сарын 28 өдөр

Дугаар А/97

Баян-Өндөр сум

Тохиолдлын удирдлагын баг
шинэчлэн томилох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.5 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.1.1, 12.1.4 дэх заалт, Дархлаажуулалтын тухай хуулийн 5 дугаар зүйлийн 2 дахь заалт, 8 дугаар зүйлийн 1 дэх заалт, 10 дугаар зүйлийн 1 дэх заалт, Эрүүл мэндийн сайдын 2022 оны "Журам заавар батлах тухай" А/373, 2024 оны "Тохиолдол удирдлагын баг томилох тухай" 437 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх тохиолдлын удирдлагын багийн бүрэлдэхүүнийг нэгдүгээр, чиг үүргийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Батлагдсан бүтэц, чиг үүргийг хэрэгжүүлж, Томуу, томуу төст өвчнөөс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг хэрэгжүүлэх ажиллахыг багийн дарга (П.Хишгээ), дэд дарга (Б.Оюуномин), гишүүдэд тус тус үүрэг болгосугай.
3. Томуу, томуу төст өвчний үеийн бэлэн байдлыг хангаж, урьдчилан сэргийлэх ажлыг эрчимжүүлэн, эмнэлгийн тусламж үйлчилгээг чанартай үзүүлж ажиллахыг бүх шатны эрүүл мэндийн байгууллагын захирал, дарга, эрхлэгч нарт үүрэг болгосугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Бодлого төлөвлөлт, хууль эрх зүй, тусгай зөвшөөрөл хариуцсан ахлах мэргэжилтэн (Б.Уртнасан)-д даалгасугай.
5. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан даргын 2024 оны 11 дугаар сарын 11-ний өдрийн А/88 дугаар тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА



Ц.МӨНХЦЭЦЭГ

Тохиолдлын удирдлагын
багийн дарга:

Тохиолдлын удирдлагын багийн
дэд дарга:
Нарийн бичиг:

Төлөвлөлтийн багийн дарга:

Гишүүн:

Эрсдлийн харилцааны багийн
дарга:

Хариу арга хэмжээ
хэмжээний багийн
дарга:
Тархвар
судлалын тандалт
хариуцсан гишүүн:

Эмнэлгийн тусламж үйлчилгээ
эмнэлзүйн асуудал хариуцсан

ЭМГ-ын Эмнэлгийн тусламжийн
чанар эрсдэл магадлан итгэмжлэл
хариуцсан ахлах мэргэжилтэн
ЭМГ-ын Яаралтай, гамшгийн үеийн
тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Дархлаажуулалт, зоонозын
халдварт өвчний тандалт,
сэргийлэлт хариуцсан мэргэжилтэн
Бүсийн оношилгоо эмчилгээний
төвийн тархвар судлаач
ЭМГ-ын Анхан шатны эрүүл мэндийн
байгууллага, ахмад настны
тусламж үйлчилгээ хариуцсан
мэргэжилтэн
ЭМГ-ын Хүүхэд, өсвөр үеийн
эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Сувилахуй болон хөнгөвчлөх,
тусламж үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн боловсрол сургалт
сурталчилгаа, олон нийт хариуцсан
ахлах мэргэжилтэн
ЭМГ-ын Орчны эрүүл мэнд, нөлөөллийн
үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Мэдээлэл технологи, цахим
эрүүл мэнд, байгууллагуудын үйл
ажиллагааны автоматжуулалт,
сүлжээ хариуцсан мэргэжилтэн
Эрүүл мэндийн газрын зураглаач,
эвлүүлэгч
ЭМГ-ын Дархлаажуулалт, зоонозын
халдварт өвчний тандалт, сэргийлэлт
хариуцсан мэргэжилтэн
БОЭТ-ийн Статистикийн мэдээллийн
албаны дарга
ЭМГ-ын Халдварын сэргийлэлт,
хяналт эмнэлгийн дотоод халдвар
хариуцсан мэргэжилтэн
ЭМГ-ын Халдварт бус өвчний
тандалт, сэргийлэлт хариуцсан
мэргэжилтэн
Бүсийн оношилгоо эмчилгээний
төвийн тархвар судлаач
Бүсийн оношилгоо эмчилгээний
төвийн вирусологи лабораторын эмч
Бүсийн оношилгоо эмчилгээний
төвийн эмнэлзүй эрхэлсэн

гишүүн:

орлогч захирал

Жаргалант сумын эрүүл мэндийн

төвийн дарга

Өрхийн анагаах ухааны холбооны тэргүүн

Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн

Чандмань-Эрдэнэ холбооны тэргүүн

Хавдрын төрөлжсөн төвийн

эмчилгээ эрхэлсэн орлогч дарга

Бүсийн оношилгоо эмчилгээний

төвийн хүүхдийн тасгийн эрхлэгч

Санхүү, нөөцийн багийн дарга:

ЭМГ-ын Эрүүл мэндийн эдийн

засаг, төсвийн төлөвлөлт, зохицуулалт

хариуцсан мэргэжилтэн

ЭМГ-ын Уламжлалт анагаах ухаан,

сэргээн засах тусламж үйлчилгээ,

хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн

асуудал хариуцсан мэргэжилтэн


ЭМГ-ын Эмийн бодлогын хэрэгжилт,

чанар аюулгүй байдал, зохистой

хэрэглээ хариуцсан мэргэжилтэн

БОЭТ-ийн Эмзүйн тасгийн эрхлэгч

Эрүүл мэндийн газрын даргын 2025 оны
41 сарын 28-ны өдрийн
А/92 дугаар тушаалын хоёрдугаар хавсралт



ТОХИОЛДЛЫН УДИРДЛАГЫН БАГИЙН БҮТЭЦ, ЧИГ ҮҮРЭГ

Нэг. Тохиолдлын удирдлагын багийн бүтэц

- 1.1. Тохиолдлын удирдлагын баг нь Тохиолдлын удирдлагын багийн дарга, дэд дарга, Эрсдэлийн харилцааны баг, Хариу арга хэмжээний баг, Төлөвлөлтийн баг, Санхүү, нөөцийн зохицуулалтын баг гэсэн 4 мэргэжлийн багтай байна
- 1.2. Тохиолдлын удирдлагын мэргэжлийн баг, бүрэлдэхүүнийг "Ажиглалтын үе"-д томилж, баталгаажуулан сургаж, бэлтгэсэн байна.
- 1.3. Тохиолдлын удирдлагын баг нь томуугийн дэгдэлт эхэлсэн тохиолдолд хариу арга хэмжээний горимоор ажиллана.

Хоёр. Тохиолдлын удирдлагын багийн үндсэн чиг үүрэг, идэвхжлийн зэрэг

- 2.1. Тохиолдлын удирдлагын баг нь томуу, томуу төст өвчин (ТТӨ)-ий дэгдэлтээс урьдчилан сэргийлэх, бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээг шуурхай хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулж ажиллана.
- 2.2. Багийн үйл ажиллагаа нь ТТӨ, Амьсгалын замын цочмог хүнд халдвар (АЗЦХХ)-ын тархалтын түвшингээс хамаарч "Ажиглах үе", "Анхааруулах үе", "Хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх үе", "Хариу арга хэмжээг бууруулах үе", "Тохиолдлын удирдлагын багийг цуцлах үе" гэсэн 5 үед хуваагдана.
- 2.3. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшинг Эрүүл мэндийн сайдын 2022 оны А/373 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын дагуу тооцно.
- 2.4. **Ажиглах үе**
 - 2.4.1. Ажиглах үе гэдэг нь ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-гээр "Улирал хоорондын үе"-д байхыг хэлнэ.
 - 2.4.2. Тохиолдлын удирдлагын мэргэжлийн багуудын бүтэц, бүрэлдэхүүнийг тодорхойлж, бие бүрэлдэхүүнийг сургаж бэлтгэсэн байна.
 - 2.4.3. Холбогдох тушаал, журам, зааврын дагуу эрүүл мэндийн байгууллагуудын бэлэн байдлыг хангасан байна.
 - 2.4.4. Салбарын болон салбар хоорондын хамтарсан хариу арга хэмжээний төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангасан байна.
 - 2.4.5. ТТӨ-ний дэгдэлтийн үеийн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулж, батлуулсан байна.
 - 2.4.6. Эмнэлгийн тусламж үйлчилгээнд шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, лабораторийн урвалж оношлуур, хэрэгслийг худалдан авах, нөөцийн тасралтгүй байдлыг хангах, аж ахуй нэгж, сорьц тээвэрлэх байгууллага зэрэг холбогдох байгууллагуудтай гэрээ, хэлэлцээрийг хийсэн байна.
 - 2.4.7. Улирлын томуугийн вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулсан байна.
- 2.5. **Анхааруулах үе**
 - 2.5.1. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр "Идэвхжлийн түвшин"-д шилжсэн үеийг хэлнэ.
 - 2.5.2. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь УТТЦХҮ-ээр "Идэвхжлийн түвшин"-д шилжсэн тохиолдолд Тохиолдлын удирдлагын багийн даргад мэдээллийг 24 цагийн дотор хүргүүлнэ.
 - 2.5.3. Тохиолдлын удирдлагын багийн дарга ТТӨ, АЗЦХХ нь УТТЦХҮ-ээр идэвхжлийн түвшинд шилжсэн болохыг мэргэжлийн багийн ахлагч нарт

мэдээлж, хариу арга хэмжээг авч хэрэгжүүлэх бэлэн байдлыг хангах үүрэг өгнө.

- 2.5.4. Эрүүл мэндийн байгууллагуудын ТТӨ, АЗЦХХ-ын тархварзүй, эмнэлзүй, вирус судлалын тандалтыг эрчимжүүлнэ.
- 2.5.5. Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг болон хүн ам ихээр цуглардаг газар, хаалттай орчин бүхий байгууллагуудад голомтолсон өвчлөл, үйл явдлын тандалтыг нэмэгдүүлнэ.
- 2.5.6. Нийгмийн эрүүл мэндийн төв (НЭМТ) нь хүн амд ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх талаар сургалт, сурталчилгааг эрчимжүүлэн цахим тандалтыг хийж, ЭМГ болон АЗДТГ-т долоо хоног бүр мэдээлнэ.
- 2.5.7. Эрүүл мэндийн байгууллагуудаар дэмжлэгт хяналт хийж, бэлэн байдлыг хангуулна.

2.6. Хариу арга хэмжээний үе

- 2.6.1. Хариу арга хэмжээний үе гэдэг нь ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр "Алаг цоог, улсын хэмжээний дэгдэлт, тахалт тархалтын түвшин"-д шилжсэн үеийг хэлнэ.
- 2.6.2. Тохиолдлын удирдлагын багийн дарга мэргэжлийн багуудыг хариу арга хэмжээний цар хүрээ, гүйцэтгэх үйл ажиллагаанаас хамаарч идэвхжүүлнэ.
- 2.6.3. Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөний дагуу үйл ажиллагааг зохион байгуулна.
- 2.6.4. Тохиолдлын удирдлагын багийн гүйцэтгэж буй үйл ажиллагааны талаар тохиолдлын удирдлагын багийн дарга Эрүүл мэндийн газрын даргад өдөр бүр танилцуулна.
- 2.6.5. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшинтэй уялдуулж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, үйлчилгээний газар зэрэг хүн ам олноор цуглардаг газруудын үйл ажиллагааг түр хугацаагаар зогсоох, цагийн хуваарьт өөрчлөлт оруулах саналыг холбогдох байгууллага, удирдлага, албан тушаалтанд хүргүүлж, шийдвэрлүүлнэ.
- 2.6.6. Шаардлагатай үед ор зохицуулах зохион байгуулалтыг хийнэ.

2.7. Хариу арга хэмжээг бууруулах үе

- 2.7.1. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь УТТЦХҮ-ээр "Алаг цоог дэгдэлтийн түвшин"-гээс буурч "Идэвхжлийн түвшин"-д шилжсэн үеийг хэлнэ.
- 2.7.2. Хариу арга хэмжээний цар хүрээг багасгаж, хэрэгжүүлэх үйл ажиллагаанаас хамаарч зарим мэргэжлийн багуудыг цуцална.
- 2.7.3. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин нь "Идэвхжлийн түвшин"-д шилжсэн тохиолдолд тохиолдлын удирдлагын багийн үйл ажиллагааг ажиглалтын үе рүү шилжүүлнэ.
- 2.7.4. Нэмэлтээр дайчлан ажиллуулж байсан нөөцийг холбогдох газруудад нь буцаана.

2.8. Тохиолдлын удирдлагын багийн үйл ажиллагааг зогсоож, тайван цагийн горимд шилжүүлэх

- 2.8.1. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин УТТЦХҮ-ээр "Идэвхжлийн түвшин"-гээс буурч "Улирал хоорондын түвшин"-д шилжсэн үеийг хэлнэ.
- 2.8.2. Тохиолдлын удирдлагын багийн дарга нь мэргэжлийн багуудыг цуцалж, авч хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний тайлан, үнэлгээ болон цаашид өөрчлөх асуудлыг хэлэлцэн, Эрүүл мэндийн газрын дарга болон холбогдох удирдлагуудад санал хүргүүлнэ.
- 2.8.3. Тохиолдлын удирдлагын багийн саналыг үндэслэн Эрүүл мэндийн газрын дарга тайван цагийн горимд шилжүүлэх шийдвэрийг гаргана.

Гурав. Тохиолдлын удирдлагын багийн чиг үүрэг

- 3.1. Тохиолдлын удирдлагын багийн даргын чиг үүрэг

- 3.1.1. Тохиолдлын удирдлагын багийн дарга нь ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшингээс хамаарч мэргэжлийн багуудыг үүрэгжүүлж, идэвхжүүлнэ.
- 3.1.2. ТТӨ-ий дэгдэлтийн бэлэн байдал, хариу арга хэмжээг нэгдсэн удирдлагаар хангаж, зохион байгуулна.
- 3.1.3. Тохиолдлын удирдлагын тогтолцоогоор ажиллаж, мэргэжлийн багийг идэвхжүүлэх, цуцлах, эсвэл бие бүрэлдэхүүнийг өргөжүүлэх, багасгах зэрэг шийдвэрүүдийг өвчлөлийн байдалтай уялдуулан гаргаж, хэрэгжүүлнэ.
- 3.1.4. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшингээс хамаарч хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг мэргэжлийн багуудтай хамтран удирдан боловсруулж, хэрэгжүүлнэ.
- 3.1.5. Эрүүл мэндийн сайд болон бусад дээд шатны шийдвэр гаргагч, хамтран ажиллагч байгууллагуудын удирдлагуудыг дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй арга хэмжээний талаарх мэдээллээр хамгана.
- 3.1.6. Мэргэжлийн багийн ахлагч, бие бүрэлдэхүүний үйл ажиллагаатай холбоотой шуурхай хурлыг удирдан, зохион байгуулж, хариу арга хэмжээтэй холбоотой гарсан шийдвэр, үйл ажиллагааг тухай бүрт танилцуулан багуудын уялдаа холбоог хангаж ажиллана.
- 3.1.7. Өвчлөлийн нөхцөл байдал, хариу арга хэмжээний явц, үр дүнгийн талаарх албан ёсны мэдээллийг олон нийтэд хандан хийнэ.
- 3.1.8. Мэргэжлийн байгууллагуудад өгөх мэдээлэл, иргэдэд зориулсан сургалт, сурталчилгааны материал зэргийг баталгаажуулна.
- 3.1.9. Хариу арга хэмжээний нэгдсэн тайланг хянан, баталгаажуулна.

3.2. Тохиолдлын удирдлагын багийн дэд даргын чиг үүрэг

- 3.2.1. Тохиолдлын удирдлагын багийн даргыг эзгүйд түүний чиг үүргийг шууд орон гүйцэтгэнэ.
- 3.2.2. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин, хариу арга хэмжээний үр дүнгийн талаарх албан ёсны мэдээллийг хянан, баталгаажуулна.
- 3.2.3. Мэргэжлийн багуудтай хийх шуурхай хурлын хуваарийг ТТӨ-ий тархалтын түвшинтэй уялдуулан гаргаж, тохиолдлын удирдлагын багийн даргаар баталгаажуулж, мэргэжлийн багуудад хүргүүлнэ.
- 3.2.4. Шуурхай хурлаар хэлэлцүүлэх мэдээллийг хянан, баталгаажуулна.
- 3.2.5. Мэргэжлийн багуудын үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж, зохион байгуулна.
- 3.2.6. Эрсдэлийн харилцаатай холбоотой бүх төрлийн мэдээллийн агуулгыг хянаж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар баталгаажуулна.

3.3. Нарийн бичгийн чиг үүрэг

- 3.3.1. Нарийн бичгийг тохиолдлын удирдлагын багийн дарга мэргэжлийн багуудыг идэвхжүүлэхээс өмнө томилж, үүрэгжүүлнэ.
- 3.3.2. Нарийн бичиг нь тохиолдлын удирдлагын багийн дарга, мэргэжлийн багийн дарга, хамтран ажиллагч, салбар байгууллагууд хооронд мэдээ, мэдээлэл солилцох, уулзалт, хурал зохион байгуулах үйл ажиллагааг хариуцна.
- 3.3.3. Мэргэжлийн багуудтай хийх шуурхай хурлын хуваарийг ТТӨ-ий тархалтын түвшинтэй уялдуулан гаргаж, тохиолдлын удирдлагын багийн даргаар баталгаажуулж, мэргэжлийн багуудад хүргүүлнэ.
- 3.3.4. Тохиолдлын удирдлагын багийн даргын батлан гаргасан хуваарийн дагуу шуурхай хурал зохион байгуулах, хурлын цаг, байршлыг мэргэжлийн багийн дарга нарт хүргэж, бүрэн ирцтэй оролцох тал дээр анхаарч ажиллана.
- 3.3.5. Нарийн бичиг нь мэргэжлийн багуудын дарга, бие бүрэлдэхүүний холбогдох мэдээллийг цуглуулж, бэлтгэх ба шаардлагатай үед шуурхай холбогдох, зарлан дуудаж, цуглуулах, мэдээллийг богино хугацаанд солилцох нөхцөлийг бүрдүүлж ажиллана.

3.3.6. Хариу арга хэмжээнд хамтран ажиллах байгууллагуудын холбогдох мэргэжилтнүүдийн холбоо барих мэдээллийг цуглуулж, бэлтгэсэн байх ба тохиолдлын удирдлагын багийн даргын өгсөн үүргийн дагуу байгууллагуудтай шуурхай холбогдох, мэдээлэл авах, дамжуулах ажлыг хариуцаж, зохион байгуулна.

3.3.7. Тохиолдлын удирдлагын багийн даргын зарласан өдөр тутмын хуралд оролцож, хариу арга хэмжээний чиглэлээр хамтран ажиллах байгууллагуудтай холбоотой гарсан шийдвэрийг холбогдох байгууллагуудад шуурхай хүргэнэ.

3.4. **Эрсдэлийн харилцааны багийн бүтэц, чиг үүрэг**

3.4.1. Эрсдэлийн харилцааны баг нь ТТӨ, АЗЦХХ-аас урьдчилан сэргийлэх, өвчлөл, нас баралтын тоо, дэгдэлтийн нөхцөл байдал, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээний талаар үнэн зөв мэдээллийг мэргэжлийн багуудаас цаг тухайд нь авч, мэдээлэл бэлтгэн иргэд, хамтран ажиллагч байгууллага, хэвлэл мэдээллийн байгууллагуудад шуурхай мэдээлэх үүрэгтэй.

3.4.2. Эрсдэлийн харилцааны багийн бүтэц

3.4.2.1. **Эрсдэлийн харилцааны багийн дарга**

3.4.2.2. Мэргэжлийн багуудаас мэдээ цуглуулж, нэгтгэн хэвлэлийн мэдээ, хэвлэлийн бага хурлын мэдээ бэлтгэх мэргэжилтэн

3.4.2.3. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй мэдээллийг хянах, тандах, иргэдийн дундах мэдээллийн хэрэгцээг судлах мэргэжилтэн

3.4.2.4. ТТӨ-өөс урьдчилан сэргийлэх, гэрээр эмчлэх энгийн арга зэргийн талаар зурагт хуудас, шторк, богино хэмжээний кино бэлтгэх мэргэжилтэн

3.4.2.5. Хэвлэл мэдээллийн ажилтныг зарлан дуудах, Хэвлэлийн бага хурал зохион байгуулах мэргэжилтэн

3.4.3. **Эрсдэлийн харилцааны багийн үүрэг**

3.4.3.1. Эрсдэлийн харилцааны багийн дарга нь үйл ажиллагааны төлөвлөгөөг гаргаж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулж, хэрэгжилтийг ханган ажиллана.

3.4.3.2. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин "Идэвхжлийн үе"-д шилжсэн хугацаанаас эхлээд "Улирал хоорондын түвшин"-д хүртэл ТТӨ-тэй холбоотой бүхий л сэдвээр иргэд, хамтран ажиллагч байгууллага, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдэд хэвлэлийн мэдээ, зурагт хуудас, богино хэмжээний кино гэх мэт тохиромжтой бүх хэлбэрээр бэлтгэн түгээнэ.

3.4.3.3. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин "Улирал хоорондын үе"-д байхад олон нийтийн хэвлэл мэдээллийн байгууллага, цахим хуудас, телевиз, радио болон хэвлэлийн байгууллагуудтай гэрээ хийж, мэдээлэл түгээх сувгийг тодорхой болгож, бэлэн байдлыг хангасан байна.

3.4.3.4. Шаардлагатай тохиолдолд хэвлэлийн бага хурлыг зохион байгуулах ба хэвлэл мэдээллийн байгууллагын бүртгэлийг гаргаж, дуудан цуглуулах нөхцөлийг бүрдүүлсэн байна.

3.4.3.5. Тохиолдлын удирдлагын багийн даргын иргэдэд мэдээлэл хийхэд зориулсан хэвлэлийн бага хурлын мэдээллийг бэлтгэж, танилцуулна.

3.4.3.6. Хэвлэл мэдээллийн байгууллага болон бусад байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хүлээн авч шийдвэрлэнэ.

3.4.3.7. Хэвлэл, мэдээллийн хэрэгслээр цацагдаж буй ТТӨ-тэй холбоотой мэдээллийг тандан судалж, худал, ташаа мэдээллийг залруулах, иргэдийн мэдээллийн хэрэгцээнд тохирсон мэдээллийг бэлтгэн түгээх ажлыг зохион байгуулна.

3.4.3.8. Иргэдийн онцлогт тохирсон мэдээлэл хүргэх стратегийг боловсруулж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулж, ажиллана.

3.4.3.9. Улирлын томуугийн эсрэг дархлуужуулалтын талаар мэдээлэл бэлтгэж,

иргэдийн эрүүл мэндийн боловсролыг нэмэгдүүлэх чиглэлээр ажлыг зохион байгуулна.

3.5. Хариу арга хэмжээний багийн бүтэц, чиг үүрэг

3.5.1. Хариу арга хэмжээний баг нь ТТӨ-ий дэгдэлтийн үед эрүүл мэндийн нөөцийг ашиглан дараах үйл ажиллагааг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.5.1.1. Улирлын томуугийн эсрэг дархлаажуулалтыг зохион байгуулна.

3.5.1.2. Өвчтөний эмнэлзүйн менежментийн чиглэлээр заавар, зөвлөмж боловсруулан, эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил аргагүйн зөвлөмж, дэмжлэг үзүүлнэ.

3.5.1.3. Тархварзүй, вирус судлал, эмнэлзүйн тандалт судалгаа хийж, Тохиолдлын удирдлагын багийн дарга, төлөвлөлтийн баг болон бусад мэргэжлийн багуудыг мэдээллээр хангана.

3.5.1.4. ТТӨ-ий дэгдэлтийн голомтод хариу арга хэмжээ шуурхай зохион байгуулж, хүн амын дунд халдварын тархалтыг бууруулах, эрсдэлт бүлгийн хүн амыг хүндрэх, нас барахаас сэргийлэх, халдвараас урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулж, нэгдсэн удирдлагаар хангаж ажиллана.

3.5.2. Хариу арга хэмжээний багийн бүтэц

3.5.2.1. Хариу арга хэмжээний багийн дарга

3.5.2.2. Тархвар судлал, тандалтын мэргэжилтэн

3.5.2.3. Шуурхай хариу арга хэмжээ, ор зохицуулалтын мэргэжилтэн

3.5.2.4. Эмнэлзүйн мэргэжилтэн

3.5.2.5. Лабораторийн мэргэжилтэн

3.5.2.6. Халдварын сэргийлэлт, хяналтын мэргэжилтэн

3.5.2.7. Дархлаажуулалтын мэргэжилтэн

3.5.3. Хариу арга хэмжээний багийн даргын чиг үүрэг

3.5.3.1. Төлөвлөлтийн багаас ирүүлсэн хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг хэрэгжүүлж ажиллана.

3.5.3.2. Хариу арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөөг боловсруулахад Төлөвлөлтийн багт дэмжлэг үзүүлнэ.

3.5.3.3. Хариу арга хэмжээг үр дүнтэй, шуурхай хэрэгжүүлнэ. Авч хэрэгжүүлж буй болон хэрэгжүүлсэн үйл ажиллагааны гүйцэтгэлийн тайлан, мэдээг бэлтгэж, Тохиолдлын удирдлагын багийн дарга, дэд дарга болон бусад мэргэжлийн багуудад хүргүүлж, Тохиолдлын удирдлагын багийн шуурхай хуралдаанд танилцуулна.

3.5.3.4. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын үе шат, дэгдэлтийн нөхцөл байдал болон холбогдох тоон мэдээ, эргэн мэдээллийг Тохиолдлын удирдлагын багийн дарга, дэд дарга, Төлөвлөлтийн баг болон бусад мэргэжлийн багийн дарга нарт хүргүүлнэ.

3.5.3.5. Шаардлагатай тохиолдолд шуурхай хариу арга хэмжээний багийг томилж, голомтонд хариу арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

3.5.3.6. Хариу арга хэмжээнд зарцуулах нөөцийг тооцож, хуваарилна.

3.5.3.7. Хариу арга хэмжээнд шаардлагатай хүн хүчний болон бусад эд материалын нөөц (эм, эмнэлгийн хэрэгсэл, урвалж оношлуур, сорьцын материал, хамгаалах хувцас, хэрэгсэл, тоног төхөөрөмж, тээвэр, талбар дээр ажиллахад байрлах байр, халдваргүйтгэлийн бодис гэх мэт)-ийн тооцооллыг харъяа багийн дарга нартай хамтран гаргаж, Санхүү, нөөц зохицуулалтын багт хүргэж, шийдвэрлүүлнэ.

3.5.4. Дархлаажуулалт

3.5.4.1. Улирлын томуугийн эсрэг вакцинаар эрсдэлт бүлгийн хүн амыг дархлаажуулах ажлыг зохион байгуулна.

- 3.5.4.2. Вакциныг цаг тухайд нь худалдан авах, нийлүүлэх, түгээх ажлыг орон нутгийн хэмжээнд зохион байгуулна.
- 3.5.4.3. ТТӨ-ий дэгдэлтийн үед товллын дархлаажуулалтын тасралтгүй үйл ажиллагааг хангаж ажиллана.
- 3.5.4.4. Дархлаажуулалтын дараах урвал, хүндрэлийн тандалтыг зохион байгуулж, мэдээг Тархвар судлал, тандалтын мэргэжилтэнд тухай бүрт хүргүүлнэ.
- 3.5.4.5. Дархлаажуулалтын мэдээг дархлаажуулалтыг хийж дуусах хүртэл хариуцан авч, Тархвар судлал, тандалтын мэргэжилтэнд хүргүүлнэ.
- 3.5.4.6. Дархлаажуулалттай холбоотой үүссэн аливаа асуудлыг Хариу арга хэмжээний багийн даргад танилцуулж, шуурхай шийдвэрлүүлнэ.
- 3.5.4.7. Дархлаажуулалтын үйл ажиллагаатай холбоотой шаардлагатай хүний болон эд материалын нөөцийн тооцоог гаргаж, Хариу арга хэмжээний багийн даргад танилцуулж, шийдвэрлүүлнэ.
- 3.5.5. Тархвар судлал, тандалт
- 3.5.5.1. Жилийн турш өвчлөлийн хөдлөлзүй, вирус судлал, эмнэлзүйд гарч буй өөрчлөлтийг үйл явдалд суурилсан болон Томуугийн харуулдан тандалтын тогтолцоогоор хянаж, бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудаас тархалтын үе шатаас хамааруулж нэмэлт тоон мэдээг цуглуулж, нэгтгэн дүн шинжилгээ хийж, хянана.
- 3.5.5.2. ТТӨ, АЗЦХХ-тай холбоотой цуглуулах тоон мэдээний төрөл, тооцох эрүүл мэндийн үзүүлэлт, давтамж, эргэн мэдээлэл, тайлангийн загварыг хариу арга хэмжээний багийн даргатай зөвшилцөж, батлуулна.
- 3.5.5.3. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшинг ЭМС-ын 2022 оны А/373 дугаар тушаалын гуравдугаар хавсралтын дагуу УТТЦХҮ-ий дагуу тооцож, тархалтын үе шатыг Хариу арга хэмжээний багийн дарга болон бусад мэргэжлийн багийн дарга, мэрэгжилтнүүдэд мэдээлнэ.
- 3.5.5.4. Нийгмийн эрүүл мэндийн ноцтой байдлыг үүсгэж болзошгүй үйл явдлыг илрүүлэх, гэнэтийн шинж чанартай дэгдэлт, шалтгаан тодорхойгүй голомтолсон өвчлөл бүртгэгдэх тохиолдолд Монгол Улсын Шадар сайдын 2023 оны 28 дугаар тушаалын дагуу холбогдох мэргэжилтнүүдийг оролцуулан тусгайлсан эрсдэлийн үнэлгээг хийнэ.
- 3.5.5.5. Хариу арга хэмжээний багийн дарга болон бусад багуудыг холбогдох мэдээллээр шуурхай хангаж, нотолгоонд суурилсан шийдвэр гаргах нөхцөлөөр хангана.
- 3.5.5.6. Голомтолсон өвчнийг бүртгэх, мэдээлэх, Шуурхай хариу арга хэмжээний багаас тархвар судлалын тандалтын мэдээллийг богино хугацаанд авч, нэгтгэн, Хариу арга хэмжээний багийн дарга болон холбогдох мэргэжлийн багуудад шуурхай хүргүүлнэ.
- 3.5.5.7. Аливаа тоон мэдээ, дүн шинжилгээ, тайлан, эрсдэлийн үнэлгээний дүн зэргийг Хариу арга хэмжээний багийн даргаар хянуулж, баталгаажуулсны дараа холбогдох мэргэжлийн багийн дарга, мэргэжилтнүүдэд хүргүүлнэ.
- 3.5.6. **Шуурхай хариу арга хэмжээ**
- 3.5.6.1. Шуурхай хариу арга хэмжээний мэргэжилтэн нь Шуурхай хариу арга хэмжээний багтай хамтран ажиллаж, Хариу арга хэмжээний багийн даргыг мэдээллийг хангаж ажиллана.
- 3.5.6.2. Шуурхай хариу арга хэмжээний баг нь талбар дээр очиж, ТТӨ-ий дэгдэлтийн голомтонд ажиллах ба халдварын тандалт судалгаа хийх, эмнэлзүйн тусламж үзүүлэх, вирус судлалын тандалтыг хийх, эрүүл мэндийн байгууллагад мэргэжил аргагүйн зөвлөмж өгөх, иргэдэд үнэн зөв мэдээлэл хүргэх зэрэг хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулна.
- 3.5.6.3. Шуурхай хариу арга хэмжээний баг нь тархвар судлагч, эмнэлзүйч эмч,

вирус судлаач, халдварын хяналт сэргийлэлтийн мэргэжилтэн, эрсдэлийн харилцааны мэргэжилтнээс бүрдсэн байна.

- 3.5.6.4. Шуурхай хариу арга хэмжээний багийг Хариу арга хэмжээний багийн дарга өвчлөлийн нөхцөл байдал, үйл явдлын цар хүрээнээс хамаарч томилох эсэхийг шийдвэрлэнэ.
- 3.5.6.5. Шуурхай хариу арга хэмжээний багийг дараах нөхцөлд томилно.
- 3.5.6.6. Тодорхой аймаг, дүүрэгт ТТӨ-ий тархалтын түвшин УТТЦХҮ-ээр "Алаг цоог дэгдэлт түвшин"-д шилжсэн.
- 3.5.6.7. Асрамжийн газар, хорих анги, саатуулах байр, амралт, сувиллын газар зэрэг хязгаарлагдмал орчинд 2 ба түүнээс дээш хүнд 10 хоногийн хугацаанд эмнэлзүйн ижил шинж тэмдэг илэрсэн.
- 3.5.6.8. Өвчлөлийн түвшин олон жилийн дундаас огцом нэмэгдсэн, вирусийн идэвхжил өндөр болсон.
- 3.5.6.9. Тандалт судалгаа, хэрэгжүүлсэн хариу арга хэмжээний мэдээ, тайлан болон бусад шаардлагатай мэдээллийг тархвар судлалын тандалтын багт илгээх ба яаралтай үүссэн нөхцөл байдал, хариу арга хэмжээнд тулгарч буй бэрхшээлийн талаар Хариу арга хэмжээний багийн даргад шууд мэдээлж, шийдвэрлүүлнэ.

3.5.7. Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмнэлзүй

- 3.5.7.1. Хүний нөөцийн хүрэлцээ, нэн шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийн нөөц, боломж зэрэг эрүүл мэндийн тусламж үйлчилгээний бэлэн байдал, хэрэгцээний түргэвчилсэн үнэлгээг зохион байгуулна.
- 3.5.7.2. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үед эрүүл мэндийн тусламж үйлчилгээг шуурхай, тасралтгүй үзүүлэх чадавхийн бэлэн байдлаг хангах, бэхжүүлэх чиглэлээр үйл ажиллагааг төлөвлөн, хэрэгжилтийг ханган ажиллана.
- 3.5.7.3. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үед эмнэлзүйн удирдамж, стандартыг шинэчлэн боловсруулж, анхан шатны болон лавлагаа шатны эмнэлгийн тусламж үйлчилгээний хэрэгжилтэд хяналт тавина.
- 3.5.7.4. Бүх шатанд нэн шаардлагатай тусламж үйлчилгээний хүртээмж, тасралтгүй байдлыг хангуулна.
- 3.5.7.5. Аймгийн хэмжээнд шаардлагатай вирусийн эсрэг эмийн тооцоог гаргаж, Хариу арга хэмжээний багийн даргад хүргүүлж, нөөцийг бүрдүүлэх, хангалт хийх асуудлыг шийдвэрлүүлнэ.
- 3.5.7.6. Шаардлагатай, зохистой тусламж үйлчилгээг цаг тухайд нь авах боломжийг бүрдүүлэхийн тулд эрүүл мэндийн байгууллага дээр эрүүл мэндийн тусламж үйлчилгээ хэрхэн, хэзээ, хаанаас авах зураглалыг тодорхойлж, мөрдүүлнэ.
- 3.5.7.7. Ор зохицуулалтыг зохион байгуулж ажиллана.
- 3.5.7.8. Эмнэлгийн байгууллагууд болон эрүүл мэндийн үйлчилгээний хүчин чадал/чадавхийн нөхцөл байдлын мэдээллийг тогтмол цуглуулж, Хариу арга хэмжээний багийн даргад мэдээлнэ.

3.5.8. Лаборатори

- 3.5.8.1. ТТӨ-ий үүсгэгчийг тодорхойлж, үндэсний төв лабораторит шинжилгээг баталгаажуулж, мэргэжил аргазүйн зөвлөмж өгч ажиллана.
- 3.5.8.2. Орон нутгийн түвшинд вирус судлалын танпалтын тасралтгүй байдлыг хэрхэн хангах талаар судалж, хэрэгцээний үнэлгээг хийж, Хариу арга хэмжээний багийн даргад танилцуулна.
- 3.5.8.3. Вирус судлалын лабораторийн шинжилгээнд тохирсон эмнэлзүй, тархварзүйн сорьц цуглуулах, хадгалах, тээвэрлэх чиглэлээр эрүүл мэндийн байгууллагын мэргэжилтнүүдэд сургалт зохион байгуулж,

гүйцэтгэл, чанар, аюулгүй байдлын хэрэгжилтэд тогтмол хяналт тавьж ажиллана.

- 3.5.8.4. Томуугийн улиралд вирус судлалын шинжилгээнд шаардлагатай хүний нөөц, урвалж, оношлуур, сорьц тээвэрлэх орчин, лабораторийн хэрэгсэл, сорьц тээвэрлэх тээврийн зардлын тооцоо зэргийг гаргаж хариу арга хэмжээний багийн даргад хүргүүлж шийдвэрүүлнэ.

3.5.9. Халдварын сэргийлэлт, хяналт

- 3.5.9.1. Халдварын сэргийлэлт, хяналт (ХСХ)-ын чиглэлээр мөрдөгдөж буй тушаал, журам, зааврын хэрэгжилтийг хангуулах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагуудад мэргэжил аргазүйн зөвлөмж өгч, дэмжлэг үзүүлнэ.
- 3.5.9.2. Амьсгалын замын халдварын шалтгаантай эмнэлгийн тусламж, үйлчилгээтэй холбоотой халдвар (ЭТҮХХ)-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед хариу арга хэмжээг холбогдох тушаал, журмын дагуу шуурхай авч хэрэгжүүлнэ.
- 3.5.9.3. Эрүүл мэндийн байгууллага дээр ЭТҮХХ-ын дэгдэлт гарсан болон халдвар гарах эрсдэл бий болсон үед очиж, идэвхтэй тандалт хийн, эрсдэлт хүчин зүйлийг тогтоож, таслан зогсоох арга хэмжээг авна.
- 3.5.9.4. Эрүүл мэндийн байгууллагын онцлогт тохирсон ХСХ-ын зөвлөмж, зааврыг боловсруулан, Хариу арга хэмжээний багийн даргаар батлуулж, хүргүүлнэ.
- 3.5.9.5. ЭТҮХХ-аас сэргийлэх чиглэлээр эмч, эмнэлгийн ажилтанд сургалт зохион байгуулна.
- 3.5.9.6. Эрүүл мэндийн байгууллага дээр ТТӨ-ий дэгдэлтийн үед халдварын сэргийлэлт, хяналтын арга хэмжээний тасралтгүй байдлыг хангуулах, шаардлагатай нөөцийн бүрдүүлэлтийг хийхэд дэмжлэг үзүүлнэ.
- 3.5.9.7. ЭТҮХХ-ын идэвхтэй болон идэвхгүй тандалт, судалгааг эрүүл мэндийн байгууллагууд дээр тогтмол хийж, тоон мэдээнд дүн шинжилгээ хийн Хариу арга хэмжээний багийн даргад тухай бүрт тайлагнана.

3.6. Төлөвлөлтийн багийн бүтэц, чиг үүрэг

- 3.6.1. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, дэгдэлтийн өмнө ба дараах үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг одоо мөрдөгдөж буй эрхзүйн баримт бичгийн хүрээнд боловсруулж, Тохиолдлын удирдлагын багийн дарга, мэргэжлийн багийн бие бүрэлдэхүүнээр хэлэлцэж, багийн даргаар батлуулна.
- 3.6.2. Төлөвлөгөөг одоогийн байгаа хариу арга хэмжээний нөөц, эрсдэлт бүлгийн хүн ам, өвчлөлийн түвшин зэргийг харгалзан мэргэжлийн багийн ахлагч нартай хамтран боловсруулна.
- 3.6.3. Дэгдэлтийн үед хариу арга хэмжээний цар хүрээтэй уялдуулан төлөвлөгөөнд тодотгол хийнэ.
- 3.6.4. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай, заавар, журам, түр заавар, албан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг боловсруулж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулж, холбогдох байгууллагуудад түгээнэ.
- 3.6.5. ТТӨ, АЗЦХХ-ын тархалтын түвшин буурч, УТТЦХХ-ээр "Улирал хоорондын үе"-д шилжсэн тохиолдолд авч хэрэгжүүлсэн арга хэмжээний эргэж үнэлгээг хийж, дараагийн дэгдэлтийн төлөвлөгөөнд хэрэгжүүлэх үйл ажиллагааны зөвлөмж, саналыг боловсруулна.

3.6.6. Төлөвлөлтийн багийн бүтэц

3.6.6.1. Төлөвлөлтийн багийн дарга

3.6.6.2. Мэргэжлийн багуудаас холбогдох мэдээг авч, нэгтгэн, дүн шинжилгээ хийж, эргэн мэдээ бэлтгэх мэргэжилтэн

3.6.6.3. Төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавих мэргэжилтэн

3.6.6.4. Баримт бичгийн бүрдүүлэлт хийх, архив үүсгэх мэргэжилтэн

3.6.7. Төлөвлөлтийн багийн чиг үүрэг

3.6.7.1. Төлөвлөлтийн багийн дарга нь ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үеийн бэлэн байдал, хариу арга хэмжээ, дэгдэлтийн өмнө ба дараах үед авч хэрэгжүүлэх үйл ажиллагааны нэгдсэн төлөвлөгөөг ахлан боловсруулах ажлыг зохион байгуулж, Тохиолдлын удирдлагын багийн даргаар батлуулна.

3.6.7.2. Мэргэжлийн багийн дарга нартай хамтарсан уулзалт зохион байгуулж, нөөц (эм, урвалж, оношлуур, эмнэлгийн хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, тоног, төхөөрөмж, техник хэрэгсэл, хамгаалах хувцас хэрэгсэл, халдваргүйтгэлийн бодис, хүний нөөц гэх мэт)-ийн төлөвлөлтийг хийнэ.

3.6.7.3. Хариу арга хэмжээний нэгдсэн тайланг боловсруулж, Тохиолдлын удирдлагын багийн даргад танилцуулж, холбогчид хүргүүлнэ.

3.6.7.4. Төлөвлөлт хийхэд шаардлагатай бүх төрлийн мэдээллийг мэргэжлийн төв байгууллага болон мэргэжлийн багуудаас авна.

3.6.7.5. ТТӨ, АЗЦХХ-ын өвчлөлийн мэдээ, авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ, нөөц, санхүүжилт зэрэг холбогдох мэдээллийг мэргэжлийн багуудаас авч нэгтгэн, хариу арга хэмжээний нэгдсэн тайлан бэлтгэж, төлөвлөлтийн багийн даргад танилцуулна.

3.6.7.6. Нэгдсэн тайланд дараах мэдээллийг заавал багтаасан байна.

- Дэгдэлтийн нөхцөл байдал
- Хариу арга хэмжээг хэрэгжүүлж буй байгууллага, хүний нөөц
- Тархвар судлалын чиглэлээр авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ
Эмнэлгийн тусламж, үйлчилгээ, эмнэлзүйн чиглэлээр авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ
- Вирус судлалын тандалтын чиглэлээр авч хэрэгжүүлж буй хариу арга хэмжээ
- Дархлаажуулалтын мэдээ
- Шуурхай хариу арга хэмжээний багийн авч хэрэгжүүлсэн Арга хэмжээ
- Нөөцийн ашиглалт, одоо байгаа нөөц
- Санхүүжилтийн талаарх мэдээлэл

3.6.7.7. Мэдээ, мэдээлэл авах журам, заавар, хүснэгт, маягтыг боловсруулан төлөвлөлтийн багийн даргаар батруулж, мэргэжлийн багуудад хүргүүлнэ.

3.6.7.8. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай, заавар, журам, түр заавар, албан даалгавар зэрэг бодлогын болон техникийн баримт бичгийг бүртгэж, архивлана.

3.6.7.9. Хариу арга хэмжээний тайлан, мэдээг бүртгэж, архивлана.

3.6.7.10. Санхүү, нөөцийн багаас нөөцийн бүрдүүлэлт, зарцуулалтын мэдээг авч архивлана.

3.7. Санхүү, нөөц зохицуулалтын багийн бүтэц, чиг үүрэг

3.7.1. Санхүү, нөөц зохицуулалтын багийн бүтэц

3.7.1.1. Санхүү, нөөц зохицуулалтын багийн дарга

3.7.1.2. Ложистик, сорьц тээвэрлэлтийн асуудал хариуцсан мэргэжилтэн

3.7.1.3. Салбарын хүний нөөцийн мэргэжилтэн

3.7.1.4. Эм, эмнэлгийн хэрэгслийн нөөцийн мэргэжилтэн

3.7.1.5. Санхүүгийн мэргэжилтэн

3.7.2. Санхүү, нөөц зохицуулалтын багийн чиг үүрэг

3.7.2.1. ТТӨ, АЗЦХХ-ын дэгдэлтийн үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээнд шаардлагатай нөөцийн судалгаа гаргаж, нөөцийн бэлэн байдлыг хангана.

3.7.2.2. Хариу арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай нөөцийг хуваарилах, шуурхай хүргэх, зарцуулалтанд хяналт тавина.

- 3.7.2.3. Тохиолдлын удирдлагын багийн дарга болон мэргэжлийн багуудын мэргэжилтнүүдийг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.7.2.4. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагуудын ТТӨ-ий дэгдэлтийн үед хэрэглэгдэх нөөцийн судалгааг гаргуулан, нөөц бүрдүүлэх арга хэмжээг авна.
- 3.7.2.5. Шаардлагатай үед ажиллах хүний нөөцийн судалгааг гаргаж, бэлэн байдлыг хангана.
- 3.7.2.6. Шаардлагатай үед нэмж дэлгэх орны нөөцийн судалгаа гаргаж, бэлэн байдлыг хангуулна.
- 3.7.2.7. Шуурхай хариу арга хэмжээний багуудыг үйл ажиллагаа хэвийн явуулах байр, техник тоног төхөөрөмжөөр хангана.
- 3.7.2.8. Хариу арга хэмжээний багаас ирүүлсэн нөөцийн зарцуулалтын хүсэлтийг хүлээн авч, шуурхай ханган, нийлүүлнэ.
- 3.7.2.9. Шаардлагатай эм, урвалж, эмнэлгийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүчилтөрөгч, вакцины бэлэн байгаа нөөцийн судалгааг төрөл, зүйлээр долоо хоног тутамд шинэчлэн гаргаж, Тохиолдлын удирдлагын багийн даргад танилцуулна.
- 3.7.2.10. Нөөцийн зарцуулалт, бэлэн байгаа нөөцийн хэмжээ, тоо ширхэг, ложистиктэй холбоотой мэдээллийг бэлтгэж, төлөвлөлт, хариу арга хэмжээ, Санхүүгийн багт хүргүүлж, нөөцийн тасралтгүй байдлыг хангаж ажиллана.
- 3.7.2.11. Зайлшгүй шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, тоног төхөөрөмж, хүчилтөрөгч, вакциныг түргэн шуурхай худалдан авах боломжийг бүрдүүлэн төсвийг шийдвэрлэх холбогдох арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлнэ.
- 3.7.2.12. Шаардлагатай тохиолдолд вакцин болон бусад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгслийг дотоодын эсвэл олон улсын нийлүүлэгч, байгууллагаас яаралтай худалдан авах, байршуулах, түгээх ажлыг зохицуулна.
- 3.7.2.13. Дайчлагдан ажиллаж байгаа хүний нөөцийн илүү цагийн цалин хөлсийг шийдвэрлэнэ.